

МОНГОЛ АМАН ЗОХИОЛЫН ОНОЛ СУДЛАЛЫН
ТУЛГАМДСАН АСУУДЛУУД

Г. Нандинбилиг *

Манай аман зохиол судлал нь судалгааны хоёр талбарт ажиллаж ирсний нэг нь уран зохиол судлалын “томилолт”, нөгөө нь домог зүй, бэлгэдэл зүйн хүн судлал болно. Оросын хэл шинжлэлчид, утга зохиол судлагч, шүүмжлэгчдийн нөлөө бүхий аман зохиол судлал хөгжиж байсныг бид бүгд мэднэ. Харин 1980-аад оноос Францын этнологиор дамжин, өрнөдийн ардын билиг зүй, угсаатан судлалтай танилцсан ба үнэндээ сүүлийн гуч шахам жилийн турш Монгол Улсын Их сургуулийн Утга зохиолын тэнхимд монгол аман зохиолын судалгаа нэрийн доор “Ардын билиг зүйн хүн судлал” бүр тодорхой хэлбэл “Домог зүй, бэлгэдэл зүйн хүн судлал” хөгжиж байна. Ингэж хэлэхийн үндэс нь монгол соёлын гүн утгыг тайлах түлхүүр бол бэлгэдэл мөн болохыг тогтоосон бэлгэдэл зүйн судалгаа¹, түүний өрнөл болно.

Манай улсын аман зохиол судлалын түрүү үеийг авч үзвэл нэлээд нийтлэг чанартай хээрийн шинжилгээг өрнүүлж, амжилт ололт арвин байснаараа онцлог хэдий ч гагц үгийн урлагийн уран сайхнаар хэт хөөцөлдөж, аман шинжийн судалгааг орхигдуулсан, зан үйлийн шинжийг орхигдуулж, “соёлын цогц байдлыг” алдагдуулсан, ангич намч үзэл суртлын үүднээс асуудалд хандсан зэрэг нэлээд дутагдалтай байгаа юм. Аман зохиол судлал нь утга зохиол судлалын нөлөөн дор байсан үеийн цуглуулгууд, аман зохиолын шинжлэх ухааны зарчим хараахан төлөвшиж амжаагүй байсан эхин үед хэвлэгдсэн аман зохиолын эмхтгэлүүд, аман зохиол судлаачдын нийгмийн үүргийг чухалчилж байсан цаг үеийн судалгаа сурталчилгаа холилдсон эмхтгэлүүд үүнийг гэрчлэх ба эдгээр нь монгол аман зохиолын эх хэрэглэхүүнийг сурвалжлан цуглуулж, судлан хэвлүүлэх үед хийсэн “хэд хэдэн хувилбарыг харьцуулан нэгдмэл эх болгон авав”,

* МУИС-ийн Монгол хэл, соёлын сургуулийн Утга зохиолын тэнхим

¹) Эрдэм судлалын ажлаа домог зүйн судлалаар эхэлсэн профессор С.Дулам олон жилийн турш Монголын баруун, зүүн, төв, өмнөд, умард хязгаарт хийсэн хээрийн шинжилгээний ажлынхаа үр дүнд цуглуулсан үнэт материалууд болон гадаад дотоодод хэвлэгдсэн монгол аман зохиол, утга зохиолын эх бичиг сурвалжуудын жишээн дээр тулгуурлан олон жилийн нөр их хөдөлмөрийнхөө үр дүнд “Монгол домог зүйн дүр” \1989\, “Монгол бэлгэдэл зүй” / I боть: Тооны бэлгэдэл зүй, УБ, 1999, II боть: Өнгөний бэлгэдэл зүй, Зүг чигийн бэлгэдэл зүй, УБ 2000, III боть: Дүрсийн бэлгэдэл зүй, Дохио зангааны бэлгэдэл зүй, УБ, 2001, IV боть: Зүүд зөн совингийн бэлгэдэл зүй, Цагийн бэлгэдэл зүй, УБ, 2002/ хэмээх дөрвөн боть бүтээлийг хэвлүүлснээр монгол аман зохиол судлал онол арга зүйн шинэ шатанд гарсан гэж болно.

“сийрүүлэн авав”, “хоёр эхийг тохиолдуулан найруулан авав” гэх мэт тайлбараараа танигдаж байдаг билээ.

Өнөөдөр монгол аман зохиол судлалын өмнө тулгамдаж буй асуудлыг бид дараах гурван хүрээнд харж байна. Үүнд:

1. Эх хэрэглэхүүний **жинхэнэ ба хуурмаг чанарын** асуудал
2. Аман **соёлын цогцолбор** байдлын судалгааг (аман зохиолын **аман шинжийн ба зан ааль, зан үйлийн** судалгааг) нөхөн хөгжүүлэх
3. Аман зохиолын онол, арга зүйг хөгжүүлэх зэрэг болно.

Эдгээрээс бид энэ удаа монгол аман зохиолын жинхэнэ ба хуурмаг чанар хийгээд аман шинжийн судалгааг хэрхэн хөгжүүлэх зарим арга замыг хайж байна.

1. Эх хэрэглэхүүний жинхэнэ ба хуурмаг чанарын асуудал.

Аман зохиол судлалын орчин үеийн нэг шаардлага бол **цуглуулан буй аман зохиолын бүтээлийнхээ уг эхэд үнэнч байж, үнэн магадтай байхыг шаардах** арга барил юм. Энэ бол аман зохиол судлал үүссэн цагаас хойш аажим аажмаар нэвтэрсээр буй, энэхүү шинжлэх ухааны илүү чанд хатуу зорилгод зүй ёсоор шилжин хувьсч байгаа үзэгдэл билээ.

Аман зохиол - ардын билиг зүйн ухаан анх үүссэн цагаасаа:

- нэг талаас эх хэрэглэхүүний жинхэнэ эх буюу анхан үүслийн баларлаг шинжийг чухалчлах
- нөгөө талаас “хуурмаг хийц” буюу бүтээсэн аман зохиол

гэсэн хоёр эсрэг тэсрэг зөрчилт үзэгдэлтэй халз тулгарсаар ирсэн юм.

Аман зохиолын хуурмаг чанарын асуудал бол түүх сөхөж үзвэл XIX зууны үеийн өрнөдийн бадрангуй үзэлтнүүдийн заримдаг ардын, заримдаг хувь бодгалийн шинжтэй эрэл хайгуул хийгээд соён гэгээрүүллийн оюун санааг таягдан хаях гэсэн үзэл суртлын нөлөөнөөс үүдэлтэй байдаг. Харин манай монгол аман зохиол судлалын хувьд бол нэг талаас судлагдахууныг дан ганц үгийн урлаг гэдэг утгаар хүлээн авч ашигласан зохиолчид, утга зохиол судлагчдын нөлөөгөөр, нөгөө талаас цаг үеийн үзэл суртлын нөлөөгөөр тайлбарлагдана. Учир иймээс бид аман зохиолын жинхэнэ ба хуурмаг чанарын судалгааг хийх боломж байгаа эсэхийг туршин мэдэх зорилгоор ШУА-ын Хэл зохиолын хүрээлэнгээс эмхтгэн гаргасан эмхтгэл хэвлэлүүдийг шүүж үзээд, эх сурвалжаа мэдээлэх тал дээр академич Д.Цэрэнсодномын эмхтгэсэн хэвлэлүүд хамгийн шинжлэх ухаанч байсан тул “Монгол ардын үлгэр” (1982) номыг сонгон авч, түүний дотроос “Гал улаан хаан” үлгэрийг сонгон судалгаа хийж үзсэн билээ.

Зөвхөн нэг үлгэрээр түлхүүр болгон судалж үзэхэд түрүү үеийн аман зохиол судлаачид нь эх хэрэглэхүүнийг тэмдэглэх болоод хэвлэлд бэлтгэхдээ:

- *Хувилбар хэсэг бүрийг хаалт хашилтаар нарийн ялгаж эмхтгээгүй*
- *Үг үсэг, өгүүлбэр, цогцолбор нэмэх буюу хассан*
- *Дүр, өгүүлэмж нэмэх буюу хассан*
- *Хэл найруулгыг эдүгээчилсэн*
- *Үг хэллэг нэмсэн, сольсон зэрэг алдааг гаргаж байв. Энэ нь шинжлэх ухааны зарчим хараахан боловсронгуй болоогүй үеийн алдаа болох нь мэдээж боловч аман зохиолын эх хэрэглэхүүнийг хэвлэн нийтлэх, эрдэм шинжилгээний эх*

*бэлтгэх явцдаа засварлаж, хуурмаг хийц болгох явдал нийдэм байсныг баталж байсан юм*²

Харин энэ дашрамд цохон тэмдэглэхэд академич Д.Цэрэнсодном “Монгол ардын үлгэр” (1982) номыг эмхтгэн хэвлүүлэхдээ эрдэм шинжилгээний тайлбарыг нягт нямбай бичиж өгснөөрөө Хэл зохиолын хүрээлэнгийн хөмрөгт хадгалагдаж байгаа үлгэрийн эх хэрэглэхүүний хадгалалт хамгаалалтад хяналт тавих хийгээд “аман зохиолын жинхэнэ ба хуурмаг чанарын” талаар хожим судалгаа хийх боломжийг бүрдүүлсэн төдийгүй монгол аман зохиол судлалын түүхэнд эмхтгэлийн эх бэлтгэхдээ эх сурвалжаа нарийн нягт тэмдэглэх шинжлэх ухааны зарчмын дэвшлийг авчирсан байна.

Аман зохиолын зүйлийг зарим үед бага зэрэг засч янзалснаараа уншигчдын шаардлагад илүү нийцсэн бүтээл болж, аман зохиолыг сонирхох олны сонирхлыг өрнүүлэх эерэг талтай байдаг ч орчин үеийн шинжлэх ухааны зарчмын үүднээс бол :

- Аман зохиолын эх хэрэглэхүүнийг эвдэх,
- Судалгааны үнэнд хүрэх үнэн зөв материал дээр ажиллах боломжийг ээдрээтэй болгох
- Хийсэн судалгааны шинжлэх ухааны үнэ цэн няцаагдах,
- Шинжлэх ухааны судалгаа биш, үндэстний сурталчилгаа болж хувирах гэх мэт эрсдлийг дагуулж байдаг юм.

Орчин үеийн аман зохиол судлаачид ч бас энэ нөхцөл байдалд аман зохиолын эх хэрэглэхүүнд ихэд анхааралтай хандах шаардлагатай болсон бөгөөд тухайлбал, Америкийн аман зохиол судлаач Ричард М.Дорсон жинхэнэ чанар нь эргэлзээтэй бүтээлийг жинхэнэ “folklore”-оос ялгахын тулд, “*fakelore*”³ хэмээх үгийн тоглоомоор ялган нэрлэх санал хүртэл гаргасан байна.

Энэ бүхэнтэй зэрэгцээд өнөөгийн ардын урлагийн дахин сэргэлт нь нэг талаас аж үйлдвэржсэн буюу уул уурхайжсан иргэншлийг эсэргүүцсэн чанартай, анхдагч жинхэнэ мөн чанараа аль болох хадгалсан соёл, аж байдлаа эргэн дурсаж, эрэн хайсан шинжтэй эерэг үзэгдэл хэдий ч аман зохиол судлалын хувьд бол хуурмаг чанарын асуудлыг үүсгэдэг билээ. Орчин үеийн аман зохиол судлаачид ч бас энэ нөхцөл байдалд аман зохиолын эх хэрэглэхүүнд ихэд анхааралтай хандах шаардлагатай болсон билээ.

Манай оронд өдгөө үндэсний ухамсар сэргэж, өөрийн уламжлалт ёс заншил, аман соёлоо эрхэмлэн сэргээх хандлага бий болж байгаа нь сайшаалтай ч яг үүнтэй зэрэгцээд нийгэмд аман соёл хийгээд ардын урлагийн зүйлсийг хувирган ашиглахад чиглэсэн янз бүрийн үйл ажиллагаа болж байна. Тухайлбал, аялал жуулчлалын хөгжлийг дагалдан ардын хөгжим, дуу, бүжиг бүхий язгуур урлагийн хамтлаг чуулга олшрохын хэрээр уламжлалт барил нь эвдрэх, уламжлалт гэр сууц, гоёл чимэглэлд зориулсан хуучин эдлэлийг хуулбарлах, аман соёлын мартагдсан юм уу хуучирсан уламжлалаас санаа сэдэл авч хувирган зохиох, зарим бүтвэрийг нь өөрчлөх, харь соёлын зүйлтэй хольцолдуулан этгээд жиг хачин (экзотик) байдлыг бүтээх замаар орчин цагийнхны таашаал сонирхолд нийцүүлэн өөрчилж ашиг олох гэсэн соёлын аж үйлдвэрлэлийн

²⁾ Цэрэнбат Н. “Гал улаан хаан” үлгэрийг аман зохиолын жинхэнэ болон хуурмаг хийцээр шинжлэх нь. Антоон Мостаэрт МСТ, Эрдмийн хэлхээ” ЭШ-ний бичиг Боть 1. УБ., 2012, 45-р тал

³⁾ *fakelore* - “будмал аман зохиол” гэсэн шиг утгатай.

(culturalindustry) шинжтэй үйл ажиллагаа өрнөж байна. Мишел де Серто, Доминик Жулиа, Жак Ревел нарын санал болгосон “*үхлийн гоо сайхан*” гэдэг хэлц хэллэг ч чухам ийм нөхцөл байдлыг хэлсэн юм. Энэ юу гэсэн үг вэ гэвэл, аман зохиол судлаачдын хувьд нэгэн түүхэн тодорхой үед гоо сайхан сэтгэл хөдлөлийн шинэ шаардлага тааламжид нийцэх, тааран зохицохоос илүү уг гоо сайхан ба судлагдхууныг алга болохоос өмнө аврах нь илүү чухал гэсэн үг юм.

Иймээс бид цаашид энэ алдааг үргэлжлүүлэн давтахгүйн тулд

- Өмнө хэвлэгдэж, судалгааны эргэлтэнд орсон аман зохиолын эх хэрэглэхүүнүүдэд “жинхэнэ ба хуурмаг чанар”-ын анализ хийж, үнэн магадтайг нягтлах,
- Цаашид аман зохиолыг сурвалжлан цуглуулах, судлан хэвлүүлэх арга зүйдээ шинэчлэл хийж, шинжлэх ухааны орчин үеийн онол шаардлагад нийцүүлэх шаардлагатай юм.

Энэ бол нэг талаас судлаачийн зүгээс судалгааны эх хэрэглэхүүнээ хэрхэн тэмдэглэх, хэвлэн нийтлэх, цаашилбал хэрхэн сонгох арга зүйн асуудал болно. Аливаа судалгаа үнэн зөв дүгнэлтэд хүрэхийн тулд хамгийн чухал нь үнэн зөв эх хэрэглэхүүн дээр ажиллах хэрэгтэй. Арга зүйн хувьд өмнө хэвлэгдэж, судалгааны эргэлтэнд орсон эх хэрэглэхүүнд “жинхэнэ ба хуурмаг чанар”-ын анализ хийж, үнэн магадтайг нягтлахын тулд хээрийн шинжилгээний баримтад тулгуурлан анхны эхийг аль болох нөхөн сэргээх (хэвлэгдсэн эмхтгэлүүдийн эх хэрэглэхүүнийг нягтлах, хэвлэлээс хэвлэл дамжин гарч буй өөрчлөлт хувиралыг илрүүлж, алдааг залруулах), хувь хүний цуглуулгын материалуудыг он цаг өнгөрч, үрэгдэхээс өмнө сурвалжлан олж, баримтжуулан үлдээх тал дээр дэмжиж ажиллах чухал юм. Тэрчлэн судлаач бүр өөрийн судалгааны үнэн магадтайд итгэлтэй байхын тулд судлаачид аль болох нэгдүгээр гарын эх хэрэглэхүүнд тулгуурладаг ч зайлшгүй өмнө хэвлэгдсэн эх хэрэглэхүүнийг судалгаанд ашиглах шаардлага тулгардаг. Өмнө хэвлэгдсэн эх хэрэглэхүүнийг судалгаанд ашиглахад ном зүйн зарчмыг эх судлалын зарчимтай хослуулан баримтлах ба аль болох анхны эхэд үнэнч байх зарчим баримтлахыг санал болгож байна. Үүний тулд:

- Тухайн эх хэрэглэхүүн хэзээ, хаана, хэдэн удаа хэвлэгдсэнийг бүртгэх
- Тухайн эх хэрэглэхүүнийг эрдэм шинжилгээний байгууллагаас эрхлэн гаргасан эсэх буюу хэвлэлийн зорилгыг нягтлах. Жишээлбэл: Хэвлэлийн өмнө хэргээ “*Унших бичиг*” гэж бичих юм уу “АБЯХ” (*Ардын боловсролын яамны хэвлэл*) гэж тавьсан түрүү үеийн хэвлэл бол уншигчдад зориулан найруулсан байдаг тул эрдэм шинжилгээнд ашиглахад учир дутагдалтай. Зүй нь ШУА-ийн ХЗХ, МУИС, МУБИС гэх мэт эрдэм шинжилгээний байгууллагаас эрхлэн гаргасан хэвлэлийг л эрдэм шинжилгээний зориулалтаар ашиглах хэрэгтэй\
- Тухайн эх хэрэглэхүүнийг эмхтгэсэн, эрхлэн гаргасан хүний мэргэжил, эрдэм шинжилгээний туршлага, байр суурийг баримжаалах
- Эх бичвэр бүрийн анхны эхийг эрхэмлэх. Боломжтой бол шинжлэх ухааны байгууллагуудад хадгалагдаж буй хээрийн шинжилгээний ажлын анхны эхийг баримтлах, боломжгүй тохиолдолд анхны хэвлэлийг олж үзэх
- Дам хэвлэлээс ашиглах гэж буй бол хэвлэлээс хэвлэлд хувирал гарсан эсэхийг шалгаж нягтлах нь чухал юм.

2. Аман соёлын цогцолбор байдлыг нөхөн хөгжүүлэх

Аман шинж гэдэг бол аман зохиолын гадагш илтгэх мэдээлэх арга барилтай холбоотой шинж юм. Энэ бол аман зохиолын тухайн төрөл зүйлсийг хүүрнэн өгүүлэх байдлаар юм уу ая аялгуугаар, эсвэл жүжиглэн наадах байдлаар үзэгч сонсогчдын дунд ардын авьяас билигтэн биечлэн үзүүлж, сонсогч, дүрслэх бүтээл мөн гэдэгтэй холбоотой шинж юм. Анх үүсэл гарлаасаа болон уг зорилго зориулалтаараа **“амнаас сонорт дамжих”** замаар тархдаг уламжлалтай, угаас бичиж тэмдэглэхэд зориулагдаагүй, харж уншихад огт зориулагдаагүй байдаг аман зохиолын аман шинжийн гол учир ялгаа оршино.

Аман шинжийн цогцолбор гэдгийг юун түрүүнд амаар зохиогдон уламжлах, хувилбар үүсэх шинж ба амаар аялгуулах, шүлэглэх, хүүрнэх зэрэг сонорт сонсогдох шинжүүд, цаашилбал, тухайн аман зохиолч болгоны хувь бодгалийн авьяас билиг, илтгэх илэрхийлэх намба намжир, нүүр царайн хувирал, биеийн дохио зангаа, дуу хоолойн өнгө өндөрсөх намсах, чимээ алдрах, гэнэт түргэсэх, өндөрсөх зэрэг үсэг бичгээр бичиж тэмдэглэх боломжгүй зүйлс тодорхойлж байдаг оршдог юм. Ардын үлгэрч, аман зохиолчдын үзэл төсөөллөөр аман бүтээл туурвил бол ерийн нэгэн зугаа цэнгэлийн үзүүлбэр бус харин аман зохиолд гарч байгаа хийсвэр бодот байдлыг бүтээх, нүднээ үл үзэгдэх сайн муу баатруудыг амилуулан **“босгох”, “дуудах”** бэлгэдлийн танивар дохио болдог. Өөрөөр хэлбэл энэ бүх зүйлс бол цаанаа ямар нэгэн **“дуудлагатай зүйлс”** учраас бичиг үсгээр бус, **заавал дуу авиагаар илэрхийлэх шаардлагатай** байдаг учир зориулалтын мөн чанар нь оршино.

Энэ аман шинж нь бичигт тэмдэглэснээр алга болдог, тэр тэмдэглэлийг сэргээн уншихад эргэн босч ирдэггүй тийм онцгой өвөрмөц чанарын цогцолбор мөн. Зарим аман зохиолчдын итгэл үнэмшил ёсоор аман шинжийг дуут дүрсээр үлдээхэд тэдгээр дуут дүрс нь тэдний тэр хийсвэр уран сайхны ертөнцийг амилуулан босгох боломжтой гэж үзэж, бичмэл зүйлсийг ийм нөлөөгүй гэж итгэсээр байна. Аман зохиол судлаачдын орхиж мартаж болшгүй гол зүйл бол энэхүү аман шинжийн цогцолбор үзэгдлүүд, түүний бичигт тэмдэглэж болшгүй байдал, бичгийн тэмдэглэлээс сэргээх боломжгүй байдлыг гол болгон ангилж, өвөрмөц мөн чанарыг нь нээн судлах чухалтай юм. Энэ бүхнээс үүдэн үзэхэд аман шинж гэдэг ойлголт бол аман зохиолын судлагдахууны хамгийн амин сүнс болсон ухагдахуун мөн билээ.

Нөгөөтэйгүүр, аман зохиолын зан аалийн болон зан үйлийн шинжийн судалгааг нөхөн хөгжүүлэх ч чухал юм. Аман зохиолын зүйл нь тэр л орчин ахуйгаасаа холдохоороо зан үйлийн **“амьд”**-лаг байдлаа алддаг билээ. Жишээ нь: Морины цол нь айраг наадмаасаа салахаараа, уртын дуу нь найрнаасаа гарч, тайзан дээр гарахаараа зан үйлийн шинж нь алдагддаг. Аман зохиолчдын одоогоор ховордож үгүй болж буй уламжлалыг амжин судлах, ардын уламжлалт мэдлэгээс судлан тогтоохын чухлыг, тухайлбал, манай туульчид хуурын эзэнд итгэдэг, туульсын баатруудаа амилж босно гэдэгт итгэдэг, үлгэр туульсыг ихэвчлэн харуй бүрийн цагаар хэлж хайлдаг, хайлахын өмнө сан сун тавьж, сацал өргөдөг, шинэ буурин дээр заавал үлгэр хэлэлцдэг зэрэг ёс заншлууд нотолж байна.

Орчин үеийн технологийн амжилт, дуут болон дүрст бичлэгийн ололт нь аман зохиолын аман шинж болоод зан үйлийн шинжийг хадгалан судлах боломжийг олгож байна.

3. Аман зохиолын онол, арга зүйг хөгжүүлэх

Монгол аман зохиол судлал өнөөдөр судлах зүйл хийгээд судлагдахууны хүрээгээ дахин тодорхойлох цаг нь болжээ. Дан ганц үгийн урлагаар хөөцөлдөх хуучин арга барилаасаа татгалзаж, аливаа аман соёлыг цогцолбор байдлаар нь авч судлах шаардлагатай байна. Ардын билиг уламжлал нь сонгодог соёлдоо дарагдсан өрнөдийн угсаатнуудын хувьд дахин дахин судлаад байх аман зохиол гэх юм бараг үгүй болсны зэрэгцээ зөвхөн бичигт тэмдэглэгдсэн баримтад л итгэдэг арга зүйн ч гэмээр алдааны улмаас ийм байдалд хүрсэн байдаг. Харин бидний хувьд энэ алдааг давтахгүй байх боломж одоохондоо байгаа билээ.

Эдүгээ хээрийн шинжилгээ өөрчлөгдөж, түүнийг харах хараа орчин үеийн шинжтэй болж, шинэчлэгдэж буй боловч судалгаа бол эхний гарын нүүр тулсан эх хэрэглэхүүн байх, ном хэвлэлээс дам авч ашиглахын аль нь ч байлаа гэсэн ялгаатай байдлыг л бүтээх ёстой. Манай аман зохиол судлалын хээрийн шинжилгээ нь нэлээд хэмжээгээр буухиачилсан, хуарангийн шинжтэй арга барилаар явж иржээ. Хээрийн шинжилгээний арга зүйдээ бид хүн судлалын ухааны ололт амжилтаас, юуны өмнө “биечилсэн шинжилгээний” арга зүйгээс нь суралцах хэрэгтэй байна.

Аман зохиолыг сурвалжлан цуглуулахдаа судлаач нь аль болох анхны эхэд үнэнч байх, соёлын аман шинжийн судалгаа болон зан үйлийн шинжийн судалгааг иж бүрэн хийж, соёлыг цогцолбор байдлаар авч судлах зарчмыг баримтлах хэрэгтэй. Энэ зарчмыг нарийвчлан тодруулбал:

- Эх хэрэглэхүүнийг цуглуулахад тавигдах шаардлага
 - Эх хэрэглэхүүний оригиналь байдлыг хадгалахыг эрхэмлэх
 - Товчлон тэмдэглэж болохгүй
 - Үг хэллэгийг дөхөмчлөн сольж, өөрчилж тэмдэглэж болохгүй
 - Найруулж, нөхвөрлөн тэмдэглэж болохгүй
 - Аль хэдийн мэддэг хувилбар гэж хандаж болохгүй
 - Эх хэрэглэхүүний аман шинжийг дуу дүрсээр баримтжуулах
 - Зан үйлийн шинжийг цогцолбор дунд авч үзэх
 - Эх сурвалжийг бүрэн байцааж тэмдэглэх
 - Эх хэрэглэхүүнийг эмхтгэн хэвлүүлэхэд тавигдах шаардлага:
 - Эх хэрэглэхүүний оригиналь байдлыг хадгалах
 - Үг хэллэгийг засварлаж болохгүй, тайлбар хийж болно.
 - Нэгтгэн боловсруулж болохгүй, хувилбарыг хавсаргаж болно. Хэрвээ нэгдмэл эх бэлтгэх зайлшгүй шаардлага байвал эх хувилбаруудыг тодорхой зааглаж мэдээлэх хэрэгтэй.
 - Товчлон авч болохгүй, тэмдэглэн авч болно.
 - Найруулан авч болохгүй, хуулан авч болно.
 - Эх сурвалжаа бүрэн мэдээлэх: Тухайн аман зохиолын жишээг уламжлан дамжуулагчийн ургийн овог ба нэр, овог, нас, жил, хүйс, уугуул нутаг ус, оршин суугаа газар орон зэргийг бүрэн мэдээлэх
 - Тухайн аман зохиолыг тэмдэглэсэн мэргэжилтэн өөрийн мэдээлэл буюу нэр овог, нас хүйс, ажил алба, тэмдэглэсэн огноо, зан үйлийн нөхцөл байдлыг мэдээлэх зэрэг болно.

Аман зохиолыг сурвалжлан цуглуулахдаа, ялангуяа дуу дүрсээр баримтжуулахдаа судлагдахуунаа аль болох эвдэхгүй байх гэсэн зарчмыг баримтлах хэрэгтэй. Судлаач судлагдахуун хоёрын харилцааны тухайд авч үзвэл, судлаач нь судлагдахуунаасаа орон

зай, цаг хугацааны хувьд алс байх шаардлагын тухай “Алсалмал хараа” хэмээх онолд⁴ “гаднын нүд” буюу судлаачийн “ондоошил”, “соёлын цочрол”-ыг чухалчилдаг байсан бол “алсалмал хараа”-г “оролцогчийн хараа” залгамжилснаар судлаачийн “хэвийншил” (normalization) –ийн тухай ярьж байна. Харин монгол аман зохиол судлалын туршлагаас үзвэл судлаач нь өөрөө тухайн аман зохиол, зан үйлийг тээн уламжлагч байх нь бий. Энэ бол үнэндээ онолын хувьд “уламжлагчийн хараа” гэж нэрлэж болох гуравдагч ойлголт гарч ирж байгаа хэрэг бөгөөд судлаач судлагдахуун хоёрын харилцааны тухай өмнөх онолыг эргэлзээнд оруулж байгаа юм. Өөрөөр хэлбэл соёлыг тээн уламжлагчид маань улам бүр мэдлэг чадвартай судлаачид болсон энэ цаг үед, арга зүйн хувьд судлаач нь өөрийн үндэстний соёл, аман зохиолыг танин мэдсэнийхээ дараа “хэвийншил”-ийг даван туулж, эргэн харж чадвал, “уламжлагчийн хараа” ялан гарч болох юм. Өөрөөр хэлбэл дэлхий дахины угсаатан судлал- соёлын хүн судлалын онол бодролыг шинэ өнцгөөс харахад туслах нөөц бололцоо нь монгол аман зохиол судлалын арга зүйд байж ч мэдэх юм.

Эцэст нь дүгнэн хэлэхэд, монгол аман зохиол судлал өдгөө сэдвийн тулгамдсан асуудал төдий биш дэлхийн аман зохиол судлал, хүн судлалын хувьсал хөгжлийн явцтай хамт нэгэн үелэлд багтаж буй асуудлуудыг хөндөн ярилцахын зэрэгцээ,

1. Уран сайхан дүр дүрслэлээр улайран хөөцөлдөөд аман зохиолын жинхэнэ ба хуурмаг чанар хийгээд аман зохиолын уламжлан дамжих аман шинж, зан үйлийн талаар хайхрамжгүй хандсан өмнөх судалгааны алдааг амжиж залруулах үйлст мэргэжил нэгтнүүдээ уриалж байна.

2. Аман зохиолын зүйлийг цаашид судлахдаа аман шинж, зан ааль, зан үйлийн шинж, үндэстний сэтгэлгээний шинж (бэлгэдэлт шинж), үгийн урлагийн дүрслэг яруу шинжүүдийг цогцолбор байдлаар нь авч судлах, улмаар эх хэрэглэхүүн цуглуулах ба хэвлэн нийтлэх түвшин, онолын задлан шинжилгээний түвшинд аль алинд нь **эх хэрэглэхүүний анхны эхэд үнэнч байж, үнэн магадтай байхыг чухалчлах** үндсэн зарчмыг сануулж байна.

НОМЗҮЙ

1. Гэрэлжав (2000), *Сэндэнжавын Дулам хийгээд монгол бэлгэдэл зүй*. Монгол хэл утга зохиол” сэтгүүл, 2000 оны 2 дугаар хугацаа, 95-96.
2. Дулам С, Нандинбилиг Г. (2007), *Монгол аман зохиолын онол*. Редактор Д.Бум-Очир, Улаанбаатар,
3. Сампилдэндэв Х (2003), *Монгол судлалын нэгэн шинэ чиглэл*. Аман зохиол судлал, Studia Folclorica, Tomus XXV, Fasc. 13, Улаанбаатар, 211-216.
4. Сампилдэндэв Х, Гаадамба Ш (2006), *Монгол аман зохиол* (Их дээд сургуулийн мэргэжлийн ангийн багш, оюутан, ерөнхий боловсролын дунд сургуулийн монгол хэл, уран зохиолын багш нарт гарын авлага болгов). Редактор Г.Билгүүдэй, Улаанбаатар,
5. Нандинбилиг Г (2009), *Монгол аман зохиол судлалаас ардын билиг зүйн хүн судлал*. –“МОНГОЛ СУДЛАЛ”. МУИС. МХСС. Боть XXXI \302\ Улаанбаатар,

⁴) *Levi-Strauss Claude. Le regard Eloigne. Paris, Plon ,1983*

6. Цэрэнбат Н (2012), “Гал улаан хаан” үлгэрийг аман зохиолын жинхэнэ болон хуурмаг хийцээр шинжлэх нь. - Эрдмийн хэлхээ” ЭШ-ний бичиг, Боть 1. Антоон Мостаэрт МСТ, Улаанбаатар,
7. Dorson. R.M (2012), *Current Folklore Theories*. - “Current Anthropology”, Vol. 4, No. 1. 1963
8. *Encyclopaedia Universalis* (1993), 3-ime ed., vol. IX, Paris, 1993
9. Levi-Strauss Claude (1983), *Le regard Eloigne*. Paris, Plon ,1983
10. Копан Ж (2007), *Угсаатан судлал, хүн судлалын удиртгал*. Франц хэлнээс орчуулсан С.Дулам, хянан тохиолдуулсан Т.Төмөрхүлэг, Д.Бум-Очир, Улаанбаатар, 2007

SUMMARY

Considering the previous studies of Mongol folklore, numerous field researches have been done and got noticeable achievements, however there are some disadvantages of chasing after only word artistry, have left the oral and ritual researches and “cultural complex” study by dealing with the issues from the ideological point of view.

In conclusion,

1. We need to appeal for researchers to re-examine the previous studies which were only focused on literary artistry and ignored the authentic and pseudo characteristics of folklore, its oral and ritual tradition.
2. Further studies on folklore need to be examined the oral characteristics, manner, ritual and symbolic characters and characteristic of art of words in complex way. So that, basic principles remind us to depend on the original context of source material at both levels of collecting and compiling source materials and theoretical analysis.